



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар СХШ-2025/05

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Хараагийн бүсийн сум
дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн СХШ-2025/07/ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Хараагийн бүсийн сум дунд ойн ангийн 2023 он, 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн нь улсын бүртгэлийн 377225 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130413002 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130413401 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн дарга Р.Наран, 2-р гарын үсгийг нягтлан бодогч С.Янжинсүрэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1. 6.Байгууллага нь дарга ,ахлах инженер, Түнхэл хэсгийг хариуцсан ойн техникч, Баянгол сумыг хариуцсан ойн техникч,ашиглалт, мод бэлтгэлийн талбай тусгаарлалтыг хариуцсан ойн инженер ,нягтлан бодогч,нярав гэсэн 7оронтой ажилласан байна.

4325001118

1.7 Тус байгууллага нь Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, сумын ИТХ-ын тогтоол, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Ойн сангийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ургамлын тухай хууль, Ан амьтны тухай хууль, Усны тухай хууль, Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хууль, Ой хамгаалал, нөхөн сэргээлт, ойн нөөцийн тогтоол, шийдвэр, журам зааврыг мөрдлөг болгон хэрэгжүүлж хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажилласан байна.

Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн хариуцсан хамгаалалтын бүсийн ой нь 322930 га, ашиглалтын бүсийн ой 65763 га, нийт 388693 га газрыг ойн сан хамаардаг. Ойжуулалт, нөхөн сэргээлт, мод үржүүлэг, талбай тусгаарлах үйл ажиллагаа явуулж байна. Бүсийн хэмжээнд нийт 28 нөхөрлөл 68511га, 23 аж ахуйн нэгж байгууллага 85566 га ойн санг гэрээгээр эзэмшин, менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 1.

Ойн сангийн талбайг бүсээр нь ангилбал:

д/д	Сумын нэр	Ойн сан /га/	Ойн сангийн бүс					Ашиглалтын бүс /га/
			Хан Хэнтийн дархан цаазат газар /га/	Ноён уулын тусгай хамгаалалтай газар /га/	Ногоон бүс /га/	Хориотой зурвасын ой /га/	100га хүртэл ой /га/	
1	Мандал	361926	181823	21670	26484	87856		65763
2	Баянгол	26767			2885	20818	3064	
	Нийт	388693	181823	21670	29369	108674	3064	65763

Мандал сумын Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай Засаг даргын 2024 оны А/155, А/309 дугаартай захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой сумын хэмжээнд хавар, намар бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг 2 удаа зохион байгуулж 3082 иргэд 232 аж ахуйн байгууллага оролцон 1,146.407 ширхэг мод тарьсан байна

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Хараагийн бүсийн сум дундын ангийн ойн ангийн нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2023 оны жилийн байдлаар 243172 ,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас орон нутгийн төсвөөс 240199,9 мянган төгрөгийг, санхүүжилт зарцуулсан, 2024 оны жилийн байдлаар 364168.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 310248.3 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс 310248.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

Мянган төгрөг

Д/Д	Үзүүлэлт	2023		зөрүү	2024		зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	243172	240199.9	2971.7	364168.3	310248.3	53920.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	243172	240199.9	2971.7	364168.3	310248.3	53920.0
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240972	237999.9	2971.7	327838.1	310248.3	17589.8
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173990.7	171936.7	2054.0	264027.6	248747.3	15280.3
5	Үндсэн цалин	101727	107273.0	-5546.0	150603.1	142039.4	8563.7
6	Нэмэгдэл	65439.7	38526.5	26913.2	99984.5	76831.4	23153.1
7	Унаа хоолны хөнгөлөлт	6824.0	6112.0	712.0	13440.0	12608.0	832.0
8	Урамшуулал	0	20025.2	20025.2	0.00	17268.5	17268.5
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21748.8	21685.2	63.6	33003.5	32028.7	974.8
11	Тэтгэврийн даатгал	14789.2	14759.7	29.5	23766.5	21635.2	2131.3
12	Тэтгэмжийн даатгал	1391.9	1527.0	-135.1	2309.3	2560.0	-250.7
13	ҮОМШӨ-ний даатгал	1739.9	1592.6	147.3	1154.6	1614.8	-460.2
14	Ажилгүйдлийн даатгал	347.9	345.8	2.1	1154.6	1243.7	-89.1
15	Эрүүл мэндийн даатгал	3479.9	3460.1	19.8	4618.5	4975.0	-356.5
21	Хангамж, бараа материалын зардал	9461.7	9365.9	95.8	11950.00	11782.4	167.6
22	Бичиг хэрэг	2460.0	2160.0	300.0	2500.00	2651.8	-151.8
23	Тээвэр, шатахуун	6672.8	6671.0	1.8	8500.00	8485.4	14.6
24	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	328.9	235.2	93.7	450.00	145.2	304.8
26	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300	299.7	0.3	500.00	500.0	0.0
28	Эд хогшил, урсгал засварын зардал	26748.4	26,730.8	17.6	7,590.00	7,589.8	0.2
30	Тавилга	13043.8	13,034.3	9.5			0.0
31	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10893.0	10,893.0	0.0			0.0
32	Урсгал засвар	2811.6	2,803.5	8.1	7,590.00	7,589.8	0.2
33	Томилолт, зочны зардал	600	176.00	424.0	1,700.00	1,444.0	256.0
35	Дотоод албан томилолт	600	176.0	424.0	1,700.00	1,444.0	256.0
37	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1272	964.1	307.9	2,367.00	754.6	1612.4
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300	300.0	0.0	1,400.00	66.0	1334.0

40	Даатгалын үйлчилгээ	400	380.0	20.0	400.00	400.0	0.0
41	Тээврийн хэрэгслийн татвар	387	147.1	239.9	387.00	178.6	208.4
42	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70	22.0	48.0	70.00	-	70.0
44	Газрын төлбөр	115	115.0	0.0	110.00	110.0	0.0
45	Бараа үйлчилгээний бусад зардал	7150	7,141.2	8.8	7,200.00	7,131.5	68.5
46	Бараа үйлчилгээний бусад зардал	7150	7,141.2	8.8	7,200.00	7,131.5	68.5
49	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2200	2,200.0	0.0	36,330.2	770.00	35560.2
51	Бусад урсгал шилжүүлэг	2200	2,200.0	0.0	36,330.2	770.00	35560.2
52	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			0.0	35,560.2	-	35560.2
54	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2200	2,200.0	0.0	770.0	770.00	0.0
55	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	198330.9	240,199.9	41869.0	364,168.3	325,047.8	39120.5
57	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	138329.9	138,329.9	0.0	274,168.3	220,577.8	53590.5
58	Орон нутгийн төсвөөс	138329.9	138,329.9	0.0	274,168.3	220,577.8	53590.5
64	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	60000	101,870.0	41870.0	90,000.0	104,470.0	14470.0
65	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60000	101,870.0	41870.0	90,000.0	104,470.0	14470.0

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2023 онд 237999.9 мянган төгрөг буюу байгаа цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 21,685.2 мянган төгрөгийн, бичиг хэрэг зардлыг 2160,0 мянган төгрөгийн, шатахуун зардал 6671,0 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2024 онд 310248,3 мянган төгрөг байгаа цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 32028,7 мянган төгрөгийн, бичиг хэрэг зардлыг 2651,8 мянган төгрөгийн, шатахуун зардал 8485,4 мянган төгрөгийн зарцуулсан байна.

2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

2023 онд тус дансанд үндсэн үйл ажиллагаанаас 3718,8 мянган төгрөгийн орлогыг хангамжийн материал 1409,0 мянган төгрөгийн Бараа үйлчилгээний бусад зардал 2309,8 мянган төгрөгийг зарцуулсан, 2024 онд тус дансанд үндсэн үйл ажиллагаанаас 20,005,0 мянган төгрөгийн хангамжийн материал 20,005.0,0 мянган төгрөгийн Бараа үйлчилгээний бусад зардал 18,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

2.4. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Хүснэгт 3.

Мянган төгрөг

д/д	Үзүүлэлт	2023			2024		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173990.7	171936.7	2054.0	264027.6	248747.3	15280.3
2	Үндсэн цалин	101727	107273.0	-5546.0	150603.1	142039.4	8563.7
3	Нэмэгдэл	65439.7	38526.5	26913.2	99984.5	76831.4	23153.1
4	Унаа хоолны хөнгөлөлт	6824.0	6112.0	712.0	13440.0	12608.0	832.0
5	Урамшуулал	0	20025.2	-20025.2	0.00	17268.5	-17268.5
6	Гэрээт ажлын хөлс			0.0			0.0
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21748.8	21685.2	63.6	33003.5	32028.7	974.8
8	Тэтгэврийн даатгал	14789.2	14759.7	29.5	23766.5	21635.2	2131.3
9	Тэтгэмжийн даатгал	1391.9	1527.0	-135.1	2309.3	2560.0	-250.7
10	ҮОМШӨ-ний даатгал	1739.9	1592.6	147.3	1154.6	1614.8	-460.2
11	Ажилгүйдлийн даатгал	347.9	345.8	2.1	1154.6	1243.7	-89.1
12	Эрүүл мэндийн даатгал	3479.9	3460.1	19.8	4618.5	4975.0	-356.5

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал: 2023 оны жилийн эцсийн тайлангаар батлагдсан төсвөөс 20,025,2 мянган төгрөгөөр, 2024 онд 17,268.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна

Томилолтын зардал: 2023 онд 600.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 176.0 мянган төгрөгийн зарцуулсан. 2024 онд 1700.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1044,0 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.

2.5 Орон нутгийн хөрөнгөөр оруулалт түүний хэрэгжилт, үр дүн, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

2023 оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд үрийн нөөцийг бий болгох зорилгоор аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 45,061,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй шилүүлст боргоцой хатаах хатаалгын зуух 1 ширхэг, 24,289.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй үр цэвэрлэх машин /5FS-100/ 1 ширхэг, 10395,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй үр хадгалах шилэн сав 27 ширхэг (405 литрийг багтаамжтай), нийт 79,745.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. 2024 онд улсын болон аймгийн хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2.6 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна. Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийж эд хариуцагчийн картыг хөтөлж хэвшсэн байна.

Бараа материал Хараагийн бүсийн сум дундын ойн анги нь 2023 оны 140,130,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

Бараа материалын орлого 33,557.1 мянган төгрөгийн худалдсан авсан 20,605.1 мянган төгрөгийн зарцуулсан ,153,082.4 мянган төгрөгийн үлдэгдэл тайлгагдсан

Хараагийн бүсийн сум дундын ойн анги нь 2024 оны 153,082,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй. Бараа материалын орлого 30,917.0 мянган төгрөгийн худалдсан авсан 34,308.5 мянган төгрөгийн зарцуулсан 149,530.9 мянган төгрөгийн үлдэгдэл тайлгагдсан

2.7 Төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн

2023 онд байгууллагын өөрийн орлого 101,870.0 мянган төгрөг байсан бол 2024 104,470.0 мянган төгрөг болж өссөн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/372 дугаар тушаал болон Мандал сумын Засаг даргын 2022 оны А/355 дугаар захирамжийг үндэслэн, 2023 онд 7 аж ахуйн нэгж байгууллагад нийт 280 тонн хуш модны самар бэлтгэх зөвшөөрлийг 8 ширхэг үнэт цаасаар олгож, үүний үр дүнд нийт 86 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

2.7 Аймгийн ИТХ-аар баталсан 2023-2024 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод ,түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт

Мандал сумын ИТХ-ын 2023 оны 01-р сарын 31-ний өдрийн 90 дугаар тогтоолоор Мандал суманд мод бэлтгэх хуваарийг 19976,6м³ хэрэглээ ,13711,4м³ , Баянгол суманд 200м³ түлээ нийт 33688м³ бэлтгэх хуваарь,483,8 га талбайд ойжуулалт хийхээр баталсан. Мод бэлтгэлийн талбайн тусгаарлалт 101 дүгээр талбарт нийт 1002 га газар хэрэглээ болон түлээний зориулалттай мод бэлтгэх талбайн тусгаарлалт хийж, эхлэлийн акт болон технологийн картыг бүрдүүлэн ажилласан. 23 аж ахуйн нэгж болон 28 нөхөрлөлтэй мод бэлтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан. Мод бэлтгэх эрхийн бичгийг 624 ширхэг үнэт цаасаар олгож, үүний үр дүнд 184,436.7 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн. 2023 онд эдгээр эрхийн бичигт үндэслэн нийт 16,217 м³ мод, модон материалыг (үүнээс 13,933 м³ хэрэглээний, 2,284 м³ түлээний) 973 ширхэг гарал үүслийн гэрчилгээгээр баталгаажуулан олгосон.

Мандал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор нийт 28,586 м³ (үүнээс хэрэглээний 16,376 м³, түлээний 12,210 м³) мод бэлтгэх хуваарийг 20 аж ахуйн нэгж, 28 нөхөрлөл, 9 багт хуваарилан, 197 га талбайд ойжуулалт хийхээр баталсан.

Мод бэлтгэлийн 75 нэгж талбар бүхий 924 га талбайд тусгаарлалт хийсэн бөгөөд үүнээс 2 нэгж талбар (61 га) нь ашиглалтад ороогүй байна. Ашиглалтын нөөц нь дууссан 73 нэгж талбарын 47 нь (497 га) бүрэн ашиглагдсан, 20 нэгж талбар (154 га)-ыг хүлээн авч дуусгаврын акт үйлдсэн. Эдгээр талбайд хэрэглээ болон түлээний мод бэлтгэх ажлыг эхлэлийн акт, технологийн картын дагуу зохион байгуулсан. 2023 оны мод бэлтгэлийн хуваарьт үндэслэн, гэрээг сунгах тухай захирамжийн дагуу 9 аж

ахуйн нэгжид хэрэглээний 1,937 м³, түлээний 1,061 м³ мод бэлтгэх эрх олгож, 25,900 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн.

2024 онд 5 иргэн, 14 нөхөрлөл, 20 аж ахуйн нэгжид хэрэглээний 5,409 м³, түлээний 13,470 м³ модны нөөцийг бэлтгэхээр 924 га талбайд нийт 460 ширхэг мод бэлтгэх эрхийн бичиг олгож, төрийн санд 126,800 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

2024 оны эхэнд 4 төрлийн үнэт цаасны 1,218 ширхэг үлдэгдэлтэй байсан бол, тухайн онд 1,782 ширхэг үнэт цаас орлогож, 1,770 ширхгийг зарлагдаж, жилийн эцэст 1,230 ширхэг үнэт цаасны үлдэгдэлтэй болсон.

Нийт 28 аж ахуйн нэгжид 15,111.4 м³ хэрэглээний болон 3,380 м³ түлээний мод, модон материалд зориулан 1,082 ширхэг гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Илрүүлэлт нь: Албаны хэрэглээнд ашиглаж буй Land Cruiser 70 маркийн, 4200 см³ багтаамжтай автомашинд 100 км-т зарцуулах шатахууны жишиг нормыг Зам, тээврийн сайдын баталсан жишиг нормын дагуу тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албаны хэрэглээнд ашиглаж буй Land Cruiser 70 маркийн автомашины шатахуун зарцуулалтыг холбогдох хууль, журам, жишиг нормын дагуу мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Хараагийн бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн таслан зогсоох 517,3 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.


Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.


Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Хараагийн бүсийн сумдын дундын ойн ангийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 11 дугаар сарын 01 -ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТОР
 Д.ВАНЧИГМАА

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХАРААГИЙН
БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА  Р.НАРАН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОЛОГЧ
С.ЯНЖИНСҮРЭН